



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/627

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн комиссыг шинэчлэн
баталсан захирамжийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/480 дугаар тушаалын 1.4, 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтад тус тус өөрчлөлт орсонтой холбоотой аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн “Тусгай зөвшөөрлийн комиссыг шинэчлэн байгуулах тухай” А/155 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын даргаар Эрүүл мэндийн газрын дарга (Мэндбаяр)-ыг томилсугай.

3.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссыг шинэчлэн байгуулж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга буюу Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ